

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/09/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2023 ОНЫ  
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272287 Цахим хаяг: [byambasurend@audit.gov.mn](mailto:byambasurend@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга .....
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан .....
- 4.1 Ерөнхий зүйл .....
- 4.2 Материаллаг байдал .....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт .....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.28 № 01/223

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТӨВ АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН  
ЗАСАГ ДАРГА Д.БАТБИЛЭГ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 20-ны 02 дугаар тогтоолоор сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 43 зорилт 177 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 91,4%-тай буюу "Үр дүнтэй" гэж дүгнэсэн байна.

### Аудитын гол асуудал

Төв аймгийн Сүмбэр сум тайлант онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр ахуй үйлчилгээний өргөтгөл засвар, сумын төвийн тохижилт, явган зам, хүүхдийн гадна талбайн тоглоом тус тус 83,400.0 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэсэн байна. Сүмбэр сумын ЗДТГ Сүмбэр суманд байрлах ХААН банкны тооцооны төвд 2023 оны 9 сард данс нээж, дансаар техник түрээсэлсний орлого хийж үлдэгдэлтэй гарсан байна.

### Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		563,460.6	636,415.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	145,183.9	112,021.9
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	324,882.8	417,261.2
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	93,393.9	107,132.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		860,930.9	905,496.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	860,930.9	905,496.7
39200	Биет хөрөнгө		847,573.9	892,139.7
39300	Биет бус хөрөнгө	13	13,357.0	13,357.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		1,424,391.5	1,541,911.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		8,220.3	10,112.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	8,220.3	10,112.7
41300	Өглөг	17а, 17б	8,220.3	10,112.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		1,416,171.2	1,531,799.2
51	Засгийн газрын хувь оролцоо		1,416,171.2	1,531,799.2
51100	Засгийн газрын оруулсан капитал		372,566.7	372,566.7
51200	Хуримтлагдсан үр дүн		790,998.4	906,683.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		252,606.0	252,548.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		1,424,391.5	1,541,911.8

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		2,302,827.6	1,676,530.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО		200,683.0	264,375.5
110	Орлогын албан татвар		142,536.9	198,135.9
1100	Хувь хүний орлогын албан татвар		148,712.8	206,135.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-6,176.0	-8,000.0
113	Хөрөнгийн албан татвар		36,742.7	42,350.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж		21,403.5	23,889.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	595,327.4	343,293.7
120	Нийтлэг татварын бус орлого		595,327.4	322,293.7
122	Тусламжийн орлого		0.0	21,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,506,817.1	1,068,861.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,937,178.0	1,561,011.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,902,178.0	1,526,955.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,097,227.0	1,515,073.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		268,661.3	432,367.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		27,766.3	54,164.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		298,281.6	44,542.1
2104	Хангамж, бараа материалын зардал		168,400.1	300,203.6
2105	Нормативт зардал		86,131.4	86,823.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		3,844.8	5,982.4
2107	Томилолт, зочны зардал		3,591.5	3,464.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		92,716.2	7,693.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		147,833.7	579,833.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		804,951.0	11,881.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		35,000.0	34,056.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		365,649.6	115,519.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		2,992,172.4	177.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-2,626,522.8	115,342.4

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,159,000.3	4,159,000.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-116,306.4	-116,306.4
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,042,693.9	4,042,693.9
9	Тайлант үеийн үр дүн	-2,626,522.8	-2,626,522.8
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,416,171.2	1,416,171.2
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,416,171.2	1,416,171.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	343.1	343.1
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,416,514.2	1,416,514.2
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-57.4	-57.4
19	Тайлант үеийн үр дүн	115,342.4	115,342.4
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,531,799.2	1,531,799.2

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,902,678.6	1,498,530.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	200,683.0	264,375.5
110	Орлогын албан татвар	142,536.9	198,135.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	148,712.8	206,135.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-6,176.0	-8,000.0
113	Хөрөнгийн албан татвар	36,742.7	42,350.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	21,403.5	23,889.2
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,530.6	5,974.7
1181	Газрын төлбөр	13,768.0	17,334.1
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,104.9	580.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	195,178.4	165,293.5
120	Нийтлэг татварын бус орлого	195,178.4	144,293.5
122	Тусламжийн орлого	0.0	21,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,506,817.1	1,068,861.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,669,038.6	1,107,716.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,669,038.6	1,107,716.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	863,878.7	1,095,834.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	259,902.6	433,198.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,530.0	54,252.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	298,612.4	44,012.1
2104	Хангамж, бараа материалын зардал	108,463.4	122,158.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,200.0	2,372.4
2107	Томилолт, зочны зардал	3,647.5	3,764.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,699.2	3,307.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	115,823.6	432,768.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	805,159.9	11,881.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	233,640.0	390,814.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	188,918.3	399,622.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	188,918.3	399,622.4
2200	Дотоод эх үүсвэрээр	188,918.3	399,622.4
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-188,918.3	-399,622.4
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-45,100.0	-24,353.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	45,100.0	24,353.9
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-378.3	-33,162.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	145,562.2	145,183.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	145,183.9	112,021.9

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,478,001.9</b>	<b>1,300,454.0</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	942,763.5	928,365.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	928,882.2	916,484.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	390,146.4	390,935.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,394.5	49,107.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	400,198.7	387,671.9
2104	Хангамж, бараа материалын зардал	29,567.9	29,567.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,572.4	20,572.4
2107	Томилолт, зочны зардал	4,137.3	3,764.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,115.0	2,115.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,750.0	32,750.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,881.3	11,881.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,881.3	11,881.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	435,238.4	347,734.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	100,000.0	24,353.9
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,478,001.9</b>	<b>1,286,258.8</b>
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	196,031.8	191,124.4
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	969,763.5	1,049,997.2
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	243,989.4	24,137.2
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	68,217.2	21,000.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	-	31,373.9
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	0	17,178.7
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	52	52
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25	25
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25	25

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>57,376.3</b>	<b>156,993.5</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	57,376.3	106,993.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	42,769.7	83,016.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	41,948.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	5,145.6
2104	Хангамж, бараа материалын зардал	315.9	75.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	300.0	535.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,153.8	35,312.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,606.6	23,976.9
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,100.0	-
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,506.6	23,976.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	50,000.0
2200	Дотоод эх үүсвэрээр	-	50,000.0
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>57,167.4</b>	<b>156,993.5</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	57,167.4	156,993.5
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>(208.9)</b>	<b>-</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	208.9	-

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг дарга нь орон нутагтаа бүх шатны хурлын шийдвэр Засгийн газар, аймаг, сумын стратеги зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, төр, засгийн бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлан таниулж, хүн амын эрүүл мэнд, боловсрол, соёл, хөдөлмөр эрхлэлтийн чанарыг ахиулан амьжиргааны түвшнийг дээшлүүлж, байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, төрийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, мал аж ахуй, газар тариалан, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлж, сумын эдийн засгийн чадамжийг сайжруулан өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг, Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг дарга “Орон нутагтаа бүх шатны хурлын шийдвэр Засгийн газар, аймаг, сумын стратеги зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн сумын тогтвортой хөгжлийг хангах” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Төв аймгийн Сүмбэр сум тайлант онд ахуй үйлчилгээний өргөтгөл засвар 34,100.0 мянган төгрөг, сумын төвийн тохижилт, явган зам 19,800.0 мянган төгрөгөөр, хүүхдийн гадна талбайн тоглоом 29,500.0 мянган төгрөгөөр тус тус хийж гүйцэтгэсэн байна.

Төв аймгийн Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 20-ны 02 дугаар тогтоолоор сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 43 зорилт 177 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 91,4%-тай буюу “Үр дүнтэй” гэж дүгнэсэн байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг дарга төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 4, 8, 10, 12, 23, 24, 28, 30 дугаар зүйл,
- Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар бүлэг, 4, 11, 13, 20, 41, 57, 59, 66 дугаар зүйл,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3, 8, 46 дугаар зүйл

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн "Сумын дотоод хяналт шинжилгээ үнэлгээний зөвлөл байгуулж, журам батлах тухай" Б/01 тоот захирамж гаргаж, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулсан байна.

Төв аймгийн Сүмбэр сумын дотоод хяналт шинжилгээ үнэлгээний баг тайлант онд дотоод хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөө боловсруулан Засаг даргын тамгын газрын даргаар батлуулан хэрэгжилтийг гарган ажилласан байна.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг дарга 2021 онд батлагдсан 5 бүлэг бүхий Төв аймгийн төсвийн байгууллага, төсөл сангуудын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэхэд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашиглаж байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 117,520.3 мянган төгрөгөөр буюу 8,2 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	145,183.9	112,021.9	-33,162.0
Авлага	324,882.8	417,261.2	92,378.4
Бараа материал	93,393.9	107,132.1	13,738.2
Үндсэн хөрөнгө	860,930.9	905,496.7	44,565.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,424,391.5</b>	<b>1,541,911.8</b>	<b>117,520.3</b>
Өр төлбөр	8,220.3	10,112.7	1,892.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,416,171.2	1,531,799.2	115,628.0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,424,391.5</b>	<b>1,541,911.8</b>	<b>117,520.3</b>

Эх сурвалж: Сүмбэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Дээрх хүснэгтээс харахад: Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 33,162.0 мянган төгрөгөөр буурч 112,021.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Энэ нь тайлант онд орон нутгийн орлого 84,342.8 мянган төгрөгийн орлогын үлдэгдэл, орон нутгийн хөгжлийн сан 4,596.9 мянган төгрөгийн хийгдээгүй ажлын үлдэгдэл, хоршоо хөгжүүлэх сан 8,239.7 мянган төгрөг нь зээлийн эргэн төлөлтөөс төвлөрүүлсэн мөнгө, Засаг даргын Тамгын газрын арилжааны банк дахь үлдэгдэл 4,342.0 мянган төгрөг, 10,500.4 мянган төгрөгийн эм эргэлтийн сангийн үлдэгдэл нөлөөлсөн байна.

Авлага дансны үлдэгдэл 417,261.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 92,378.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Орон нутгийн хөгжлийн сан 19,489.1 мянган төгрөгөөр буурч, Хоршоо хөгжүүлэх сан 31,000.0 мянган төгрөгөөр, Засаг даргын Тамгын газар 79,734.1 мянган төгрөгөөр, Эмийн эргэлтийн сан 1,347.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 107,132.1 мянган төгрөг болж, өмнөх оноос

13,738.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Засаг даргын Тамгын газар 7,278.3 мянган төгрөг, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 1,630.5 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сан 4,829.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 905,496.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 44,565.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Эмийн эргэлтийн сан 57,740.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авснаас, Засаг даргын Тамгын газар 13,093.6 мянган төгрөг, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 80.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 10,112.7 мянган төгрөг болж 2,178.0 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь орон нутгийн ерөнхий орлогын 98.2 мянган төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн 6,116.2 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сангийн 3,898.2 мянган төгрөгийн өглөг байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ нь 1,531,799.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 115,628.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 112,021.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 33,162.0 мянган төгрөгөөр буюу 22,8 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө			
Банканд байгаа бэлэн мөнгө	145,183.9	112,021.9	-33,162.0
Төгрөг	145,183.9	112,021.9	-33,162.0
Төрийн сангийн харилцах	141,719.7	97,179.4	-44,540.3
Арилжааны банк дахь харилцах	3,464.2	14,842.5	11,378.3
<b>Дүн</b>	<b>145,183.9</b>	<b>112,021.9</b>	<b>-33,162.0</b>

Эх сурвалж: Сүмбэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн тодруулаа

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 112,021.9 мянган төгрөг нь төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд 97,179.4 мянган төгрөг, арилжааны банкны дансанд 14,842.5 мянган төгрөг байршиж байна. Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны 97,179.4 мянган төгрөгийн 86,8 хувь буюу орон нутгийн ерөнхий орлогын 84,342.8 мянган төгрөг, 4,7 хувь буюу Орон нутгийн хөгжлийн сангийн 4,596.9 мянган төгрөг, 8,5 хувь буюу Хоршоо хөгжүүлэх сангийн 8,239.7 мянган төгрөгийн үлдэгдэл байршиж байна. Арилжааны банканд ЗДТГ-ын 4,432.1 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сангийн 10,500.4 мянган төгрөг байршиж байна.

Сүмбэр сумын ЗДТГ нь Сүмбэр суманд байрлах ХААН банкны тооцооны төвд 2023 оны 9 сард 5744120463 тоот данс нээж, дансаар техник түрээсэлсний орлого 6 иргэнээс 3,248.8 мянган төгрөг төвлөрүүлж, шатахуунд 716.3 мянган төгрөг, сэлбэгт 190.0 мянган төгрөг нийт 906.8 мянган зарцуулж 2,342.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл нь 44,540.3 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оноос орон нутгийн төсвийн орлогын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 26,003.0 мянган төгрөгөөр, Хоршоо хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 4,558.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 13,978.5 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна. Арилжааны банк дахь харилцах данс буюу ЗДТГ 4,342.1 мянган төгрөгөөр, Эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл 7,036.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

1.Төв аймгийн Сүмбэр сумын ИТХ-ын даргын 2023 оны 01 дүгээр сарын 05-ний өдрийн Б/01 тоот “Бүтэц орон тоо, цалин хөлсийг шинэчлэн тогтоож, орон нутгийн нэмэгдэл олгох тухай” захирамжаар төрийн албаны улс төрийн албан хаагчийн орон нутгийн нэмэгдэлд 2,525.3 мянган төгрөг олгосон зөрчилд төлбөрийн акт бичив.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 417,261.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 92,378.4 мянган төгрөгөөр буюу 28,4 хувиар нэмэгдсэн байна.

#### Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	265.9	-	-265.9
Байгууллагаас авах авлага	28,172.5	90,030.6	61,858.0
Хувь хүмүүсээс авах авлага	296,444.3	327,230.6	30,786.2
<b>Дүн</b>	<b>324,882.8</b>	<b>417,261.2</b>	<b>92,378.3</b>

Эх сурвалж: Сүмбэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн авлагын тодруулга

Авлагын үлдэгдэлд Хоршоо хөгжүүлэх сангийн 326,280.6 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлага 78,2 хувийг, байгууллагаас авах орон нутгийн хөгжлийн сангаар хийж гүйцэтгэсэн хөрөнгө оруулалтын дутуу ажлын авлага 87,447.4 мянган төгрөг буюу 20,9 хувийг эзэлж байна. Авлага дансны жилийн эцсийн үлдэгдэл 327,230.6 мянган төгрөгийн 78,4 хувийг хувь хүмүүсээс авах авлага, 21,6 хувийг байгууллагаас авах авлага эзэлж байна.

#### Аудитын илрүүлэлт:

1. Хоршоо хөгжүүлэх сан 89 иргэний 227,269.2 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагын зөрчилд албан шаардлага өгөө.

### 3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 107,132.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 13,738.2 мянган төгрөгөөр буюу 14,7 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>	<b>14,495.6</b>	<b>19,319.2</b>	<b>4,823.5</b>
Эм боох материал	14,495.6	19,319.2	4,823.5
<b>Хангамжийн материал</b>	<b>78,898.2</b>	<b>87,812.9</b>	<b>8,914.7</b>
Бичиг хэргийн материал	980.0	1,544.5	564.5
Аж ахуйн материал	15,406.0	11,542.9	-3,863.1
Сэлбэг хэрэгсэл	329.0	2,749.0	2,420.0
Бусад хангамжийн материал	62,183.3	71,976.6	9,793.3
<b>Дүн</b>	<b>93,393.9</b>	<b>107,132.1</b>	<b>13,738.2</b>

Эх сурвалж: Сүмбэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бараа материалын тодруулга

Бараа материал дансны үлдэгдэл 107,132.1 мянган төгрөгийн 79,4 хувь буюу 85,084.2 мянган төгрөгийг Засаг даргын тамгын газар, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2,099.5 мянган төгрөг буюу 2,0 хувийг, Эмийн эргэлтийн сангийн 19,948.4 мянган төгрөг буюу 18,6 хувийг бараа материал эзэлж байна. Бараа материал данс худалдан авсан 151,817.0 мянган төгрөгөөр, шилжүүлэн авсан 5,823.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 140,292.3 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчилгүй байна.

### 3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл байхгүй байна.

### 3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 905,496.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 44,565.8 мянган төгрөгөөр буюу 5,2 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>847,573.9</b>	<b>892,139.7</b>	<b>44,565.8</b>
Барилга, байгууламж, орон сууц	755,272.8	596,784.5	-158,488.3
Авто-тээврийн хэрэгсэл	243,527.4	139,403.2	-104,124.2
Машин тоног төхөөрөмж(компьютер)	183,510.1	140,585.9	-42,924.2
Тавилга, аж ахуйн эд хогшил	45,143.9	6,363.1	-38,780.8
Зам, гүүрний байгууламж	536,275.4	0.0	-536,275.4
Бусад үндсэн хөрөнгө	19,598.9	9,003.0	-10,595.9
Ном	124.0	0.0	-124.0
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>13,357.0</b>	<b>13,357.0</b>	<b>0.0</b>
Программ хангамж	3,171.5	0.0	-3,171.5
Бусад биет бус хөрөнгө	13,357.0	13,357.0	0.0
<b>Дүн</b>	<b>860,930.9</b>	<b>905,496.7</b>	<b>44,565.8</b>

Эх сурвалж: Сүмбэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгийн тодруулга

Үндсэн хөрөнгө дансны жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдлийн 92,2 хувь буюу 835,040.6 мянган төгрөгийг сумын ЗДТГ, 0,2 хувь буюу 1,724.5 мянган төгрөгийг ИТХ, 7,6 хувь буюу 68,731.6 мянган төгрөгийг эмийн эргэлтийн сангийн хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эцэст 905,496.7 мянган төгрөг болж, худалдан авсан 52,188.0 мянган төгрөгийн хөрөнгөөр, үнэ төлбөргүй хүлээн авсан 6,843.3 мянган төгрөг, шилжүүлэн авсан 55,000.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчилгүй байна.

### 3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 10,112.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,892.3 мянган төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	285.7	-	-285.7
Бараа үйлчилгээний зардлын өглөг	98.2	98.2	0.0
Байгууллагад төлөх өглөг	7,836.5	10,014.5	2,178.0
<b>Дүн</b>	<b>8,220.3</b>	<b>10,112.7</b>	<b>1,892.3</b>

Эх сурвалж: Сүмбэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн өглөгийн тодруулга

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 10,112.7 мянган төгрөг болж, Эмийн эргэлтийн сангийн өглөг 3,042.3 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд Орон нутгийн ерөнхий орлого 98.2 мянган төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн 6,116.2 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сангийн 3,898.2 мянган төгрөг нийт 10,112.7 мянган төгрөгийн өглөг байна.

Аудитын илрүүлэлт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчилгүй байна.

### 3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,531,799.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 115,628.1 мянган төгрөгөөр буюу 8,2 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/ мянган төгрөгөөр /		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	372,566.7	372,566.7	0.0
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	790,998.4	906,683.9	115,685.5
Өмнөх үеийн үр дүн	3,417,521.2	791,341.5	-2,626,179.7
Тайлант үеийн үр дүн	(2,626,522.8)	115,342.4	2,741,865.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	252,606.0	252,548.6	-57.4
<b>Дүн</b>	<b>1,416,171.1</b>	<b>1,531,799.2</b>	<b>115,628.1</b>

Эх сурвалж: Сүмбэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,541,911.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 125,740.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь тайлант үеийн үр дүн 115,342.4 мянган төгрөгөөр, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт 285.7 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Сүмбэр сумын орон нутгийн төсвийн байгууллагуудын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,150,919.3 мянган төгрөг, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 205,060.0 мянган төгрөг, 2023 оны төсвийн жилийн урсгал үйл ажиллагааны зардлыг 1,355,979.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 5 дугаар тогтоолд зааснаар Сүмбэр сумын Засаг дарга тайлант онд 205,060.0 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 767,154.8 мянган төгрөгөөр, малын тоо толгойн албан татварын шилжих үлдэгдэл 23,000.0 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийг 157,764.5 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдэл 25,000.0 мянган төгрөг, нийгмийн хариуцлагын гэрээ болон хандивын орлого 30,000.0 мянган төгрөгөөр, сумын орон нутгийн төсвийн шилжих үлдэгдэл 48,000.0 мянган төгрөгөөр, Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн орлого 100,000.0 мянган төгрөгөөр нийт 1,355,979.3 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төслийн саналаас Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 8 дугаар сарын 21-ны өдрийн 01 дүгээр тогтоолд зааснаар Сүмбэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 216,035.7 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр тодотгон баталж гүйцэтгэлээр 279,273.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 117,3 хувиар биелүүлсэн байна.

Тайлант онд орон нутагт төвлөрүүлэх үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого 2,406.0 мянган төгрөгөөр, ойн нөөц ашигласны орлого 319.7 мянган төгрөгөөр, газрын төлбөр 11,355.9 мянган төгрөгөөр нийт 14,081.6 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь орон нутагт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлтийг нэр төрлөөр авч үзэхэд өмнөх оноос 2 нэр төрлөөр буурсан, газрын төлбөрийн орлого сүүлийн 2 жил дараалан 2,232.0-

11,355.9 мянган төгрөгөөр тасарсан нь татварын орлогын нэр төрлөөр биелүүлэх ажил хангалтгүй байна.

Төв аймгийн Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 8 дугаар сарын 21-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 723,727.8 мянган төгрөгөөр, малын тоо толгойн албан татварын шилжих үлдэгдэл 45,000.0 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийг 196,031.8 мянган төгрөгөөр, сумын орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдэл 25,000.0 мянган төгрөгөөр, нийгмийн хариуцлагын гэрээ болон хандивын орлого 68,217.2 мянган төгрөгөөр, сумын орон нутгийн төсвийн шилжих үлдэгдэл 95,989.4 мянган төгрөгөөр тодотгосон байна.

Төв аймгийн Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 8 дугаар сарын 21-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор сумын төсвийн жилд зарцуулах зардлын хэмжээг 1,470,002.0 мянган төгрөгөөр тодотгон баталсан дүн аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс ирүүлсэн болон Сангийн яамны е тайлангийн төлөвлөгөөнөөс 8,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь аймаг Сангийн яаманд төлөвлөгөөг хүргүүлэхдээ 8,000.0 мянган төгрөгөөр алдаатай тусгасан байна.

Төв аймгийн Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 8 дугаар сарын 21-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор Хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг 100,000.0 мянган төгрөгөөр хэвээр баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 20 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвийн орлогоос 235,035.8 мянган төгрөг, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс 723,727.8 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 196,031.8 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс 143,989.4 мянган төгрөг, нийгмийн хариуцлагын гэрээ болон хандивын орлого 68,217.2 мянган төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс 100,000.0 мянган төгрөгийг нийт 1,478,001.9 мянган төгрөг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,286,258.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 37,334.4 мянган төгрөгийг төвлөрүүлж, Хоршоо хөгжүүлэх санд 80,204.8 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн нь зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтөөс шалтгаалсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,300,453.9 мянган төгрөг буюу 88,0 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 177,547.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь шалтгаалсан байна.

Хөрөнгө оруулалтын 3 төсөл, 12 арга хэмжээнд 196,031.8 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 191,124.4 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

### Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага-үндсэн үйл ажиллагааны зардал	86,634.9	86,563.2	71.7	99.9
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-үндсэн үйл ажиллагааны зардал	588,427.2	580,522.7	7,904.5	98.7
3	Ерөнхий боловсролын сургууль-тогтмол зардал	134,135.8	133,961.5	174.3	99.9
4	Сургуулийн өмнөх боловсрол-тогтмол зардал	81,688.8	80,813.4	875.4	98.9
5	Соёлын үйлчилгээ-тогтмол зардал	111,498.3	109,703.4	1,794.9	98.4
6	Эрүүл мэндийн төв-тогтмол зардал	41,367.9	37,790.8	3,577.1	91.4
7	Хоршоо хөгжүүлэх сан- үндсэн үйл ажиллагааны зардал	100,000.0	24,353.9	75,646.1	24.4
8	Орон нутгийн хөгжлийн сан-хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ	334,249.0	246,745.0	87,504.0	73.8
9	<b>Дүн</b>	<b>1,478,001.9</b>	<b>1,300,454.0</b>	<b>177,547.9</b>	<b>88.0</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны захирагчаас 148,448.4 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого 8,548.2 мянган төгрөг нийт 156,993.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг дарга тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 133,016.6 мянган төгрөг зарцуулж, 23,976.9 мянган төгрөг Засаг даргын тамгын газар орон нутгийн ерөнхий орлогод төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 8 хөтөлбөрийн 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 4. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2023.01.01 2023.12.31	Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагааг төгөлдөржүүлнэ.	Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд цахим салбарыг дэмжиж иргэдэд нээлттэй хүртээмжтэй байлгах зорилгоор мэдээ мэдээллийг цахимаар тогтмол хүргэж цахимаар иргэдэд үйлчлэх боломжийг бүрдүүлэн 2 хөтөлбөр 3 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. Хэрэгжилт 100%	86,634.9	86,563.2
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01 2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 12 зорилт, хэрэгжүүлэх 34 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 98,5%	588,427.2	580,522.7
3	70106- Хоршоо хөгжүүлэх сан	2023.01.01 2023.12.31	Хоршоо хөгжүүлэх сангаас иргэн, хоршоонд олгох зээлийг журмын дагуу 3 чиглэлээр шаардлага хангасан төсөл шалгаруулан зээл олгох.	Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэлтийн хөрөнгө болон үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг үр дүнтэй санхүүжүүлсэн. Хэрэгжилт 64,4%	100,000.0	24,353.9
4	71802- Ерөнхий боловсролын сургууль	2023.01.01 2023.12.31	“Оюунлаг Төв аймаг” хөтөлбөр хэрэгжүүлж, ерөнхий боловсролын сургалтын чанарыг сайжруулан, үр дүнг ахиулна.	ЕБС-ийн багшийн ажлын гүйцэтгэл үр дүнг үнэлж, урамшуулал олгох зорилго бүхий гүйцэтгэлийн үнэлгээг үнэлж, гүйцэтгэлийн дундаж 72.5%-тай шалгагдсан.	134,135.8	133,961.5
5	71801- Сургуулийн өмнөх боловсрол	2023.01.01 2023.12.31	Сургууль, цэцэрлэг бүр хичээлээс гадуурх сургалтын үйл ажиллагааг дэмжих замаар хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлнэ.	Сургалт үйл ажиллагааг дэмжих замаар 8 төрлийн дугуйлангийн үйл ажиллагааг явуулж 109 хүүхдийг хамруулсан байна. Хэрэгжилт 100%	81,688.8	80,813.4

6	71702-Соёлын үйлчилгээ	2023.01.01 2023.12.31	Нийтийн биеийн тамир, урлаг, спортын чиглэлээр нийтийг хамарсан үйл ажиллагааг өргөжүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ	2023 оны байдлаар 13 удирдамжаар 16 төрлийн спортын арга арга хэмжээ зохион байгуулсан. Хэрэгжилт 91,3%	111,498.3	109,703.4
7	71602-Эрүүл мэндийн төв	2023.01.01 2023.12.31	Үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, үйлчилгээ үзүүлсэн хүний тоо Эрүүл мэндийн байгууллагын тоног, төхөөрөмжийн стандарт хангалтыг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулна.	Артерийн гипертензи илрүүлэх үзлэгт 1105 иргэнийг хамруулахаас 1107 иргэнийг хамруулсан. Хамралт-100%	41,367.9	37,790.8
8	70106-Орон нутгийн хөгжлийн сан	2023.01.01 2023.12.31	Суманд 3-аас доошгүй хүүхдийн тоглоомын талбай, 1000-аас доошгүй м <sup>2</sup> явган зам, 1-ээс доошгүй биеийн тамирын талбай, 2-оос доошгүй км дугуйн зам байгуулах ажлыг иргэд, аж ахуйн нэгжийн оролцоо дэмжлэгтэй хэрэгжүүлнэ	Төвийн ундны усны худаг засвар, төв зам дагуух ногоон байгууламж тохижилт, Жавхлант хорооллын гэрэлт цамхаг, Золбин нохой устгалд, сумын төвийн тохижилт явган хүний зам тавих, Бага бор болон халуун гууны худаг засвар, Огтоно устгалын зардалд, Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Хэрэгжилт 84,9%	334,249.0	246,745.0

Төв аймгийн Сүмбэр сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 64,4% тай хэрэгжсэн зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтөөс шалтгаалжээ.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг дарга тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд шууд худалдан авалтаар 194,419.0 мянган төгрөгийн 12 бараа, ажил үйлчилгээ, нээлттэй тендер шалгаруулалтаар 195,830.0 мянган төгрөгийн 5 бараа, ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 158,234.0 мянган төгрөгийн хөрөнгийг шууд худалдан авалтаар, нээлттэй тендер шалгаруулалтаар 193,730.0 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны зохих журмаар хийсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын татварын орлогын бүрдүүлэлт, биет бус хөрөнгө данс бүртгэлд тусгахтай холбоотой зөвлөмж өгөгдсөн байна.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 05/32 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2023 оны төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2023 оны төсвийн суурь үзүүлэлтийг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 1,470,002.0 мянган төгрөгийн нийт зардлаас 1,5 хувиар буюу 22,050.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 16,537.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг дарга тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвийн жилд байр ашиглахтай холбоотой зардал 12,526.8 мянган төгрөг, дотоод томилолтын зардал 373.0 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 2,000.0 мянган төгрөг, хөрөнгийн зардал 87,504.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

### **4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 178 мэдээлэл байршуулахаас 140 мэдээлэл хугацаандаа байршуулж, 37 мэдээлэл хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад таван

сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 149,678.3 мянган төгрөгийн 14 мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 161,602.6 мянган төгрөгийн 12 мэдээлэл, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэлтэй холбоотой 100,014.7 мянган төгрөгийн 2 мэдээлэл, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэлтэй холбоотой 10 мэдээлэл хугацаанд нь байршуулсан байна

#### 4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг дарга тайлант онд Хаш аранга ХХК, Нүүрс хими технологи ХХК тус бүр 10,000.0 мянган төгрөгөөр нийгмийн хариуцлагын гэрээг байгуулж, 2 аж ахуй нэгж байгууллага гэрээний үүргээ биелүүлж 20,000.0 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлсэн байна.

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.7.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдэж 2 зөвлөмж өгсөн байна.

##### 4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт, шилэн данс, төсвийн төлөвлөгөө батлахтай холбоотой 3 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын 2023 оны 6 дугаар сарын 14-ны өдрийн 05/87 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	3	881,022.0	3	881,022.0	100
Нийт дүн	3	881,022.0	3	881,022.0	100

/мянган төгрөгөөр/

#### 4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагад дараагийн аудитаар ОНХС-ийн иргэдийн санал авсан байдал, тендер шалгаруулалт, зарцуулалттай холбоотой асуудлыг гүйцэтгэлийн аудитаар авч үзнэ.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 144,619.9 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 2,342.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 142,277.8 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## **5.1 Төлбөрийн акт**

1. Сүмбэр сумын ЗДТГ санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр Сүмбэр суманд байрлах ХААН банкны тооцооны төвд 2023 оны 9 сард 5744120463 тоот данс нээж, дансаар техник түрээсэлсний орлого 6 иргэнээс 3,248.8 мянган төгрөг төвлөрүүлж, шатахуунд 716.3 мянган төгрөг, тракторын сэлбэгт 190.0 мянган төгрөг нийт 906.8 мянган зарцуулж 2,342.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Сангийн сайд, Монгол банкны Ерөнхийлөгчийн 2022 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн А122/А-172 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Засгийн газар болон төсвийн байгууллагын дансыг нээх, хаах, тайлагнах журам”-ын 2.2-т “Төсвийн байгууллага энэ журмын 2.1.1-2.1.5 дах хэсэгт заасан дансыг нээлгэхдээ санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хавсралтаар баталсан Маягт-1-ийн дагуу данс нээлгэх хүсэлтээ албан бичгээр болон цахимаар дараах мэдээллийг тусгаж ирүүлнэ”, 3.6-д Төсвийн байгууллага банк дах дансыг зориулалт бусаар ашиглахыг хориглоно” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

## **5.2 Зөвлөмж**

### **1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал**

#### Илрүүлэлт:

1. Тус байгууллага тайлант онд улсад төвлөрүүлэх орлогыг 8,895.9 мянган төгрөгөөр, орон нутагт төвлөрүүлэх орлогыг 14,421.9 мянган төгрөгөөр нийт 23,317.8 мянган төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Улс, орон нутгийн 2 шатны орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэх.

### **1. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал**

#### Илрүүлэлт:

2. Төв аймгийн Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 8 дугаар сарын 21-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор сумын төсвийн жилд зарцуулах зардлын хэмжээг 1,470,002.0 мянган төгрөгөөр тодотгон баталсан дүн аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс ирүүлсэн болон Сангийн яамны е тайлангийн төлөвлөгөөнөөс 8,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс Сангийн яаманд төлөвлөгөөг хүргүүлэхдээ 8,000.0 мянган төгрөгөөр алдаатай тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 7 дугаар зүйлийн 7.5-д “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг тухайн жилийн төсвийг эрх бүхий байгууллагаас баталсан өдрөөс эхлэн зохион байгуулж болно”, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал,

санхүүжилтийн зориулалт болон төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааг энэ хуульд заасан зарчимд нийцүүлэн Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: ИТХ-аар баталсан төсвийн төлөвлөгөөний дүн сангийн яамны е тайлангийн төлөвлөгөөнөөс зөрүүгүй байх.

## 2. Биет бус хөрөнгөтэй холбоотой асуудал

### Илрүүлэлт:

2. Газрын мэдээллийн санд бүртгэлтэй сумын Засаг даргын захирамжаар олгогдсон газрыг тулган шалгахад 110,960.0 мянган төгрөгийн 12 газар данс бүртгэлд тусгагдаагүй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 2 дугаар зүйлийн 2.5.1-д “Биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй “газар эзэмших эрх”-ийн асуудлыг шийдвэрлүүлэхэд газар эзэмших/ ашиглах эрхийн гэрчилгээ, кадастрын зураг, тухайн газар дээр барилга, байгууламжийн жагсаалт, газар шилжүүлэх болсон үндэслэл, шалтгааны тайлбар;” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Засаг даргын Тамгын газрын данс бүртгэлд тусгуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалт тай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1		1					
2	Засаг даргын тамгын газар	1	1			1			
3	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
4	Эмийн эргэлтийн сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
	<b>НИЙТ</b>	<b>5</b>	<b>1</b>	<b>4</b>		<b>1</b>			

## 7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
ИТХ	1	4,000.0			1	4,000.0	1	4,000.0		
ЗДТГ	1	736,359.2	1	2,000.0	1	734,359.2	1	736,359.2		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>740,359.2</b>	<b>1</b>	<b>2,000.0</b>	<b>2</b>	<b>738,359.2</b>	<b>2</b>	<b>740,359.2</b>		

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	4	144,619.9	1	2,342.1			3	142,277.8
ИТХ	1	2,525.3	1	2525.3				
ЗДТГ	4	57,116.6	3	10,647.6			1	46,469.0
Хоршоо хөгжүүлэх сан	1	227,269.6					1	227,269.6
<b>Дүн</b>	<b>10</b>	<b>431,531.4</b>	<b>5</b>	<b>15,515.0</b>	-	-	<b>5</b>	<b>416,016.4</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Эмийн эргэлтийн сан	1	30,945.5					1	30,945.5
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>30,945.5</b>					<b>1</b>	<b>30,945.5</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>30,945.5</b>					<b>1</b>	<b>30,945.5</b>

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)